

**ТАРВАГАНЫ ХҮН МАХНЫ БОРЦ, ТҮҮНИЙ ШАТААСАН
ҮНСЭНД ГАММА ИДЭВХЖИЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГААР
ХИЙСЭН СУДАЛГАА**

Ш.Гэрбиш*, Г.Пүрэвдорж, Н.Балжиням***, О.Отгонсүрэн***,
Б.Далхсүрэн*, Д.Баатархүү***

***МУИС, Цөмийн Судалгааны Төв, **АУИС, ***УБИС**

Төвч утга: Тарваганы хүн махны борц болон үнсний дээжинд байгаа макро, микроэлементийн хэмжээг МУИС-ийн ЦСТ-ийн электроны цикл хурдасгуур микротрон МТ-22 ашиглан гамма идэвхжилийн аргаар тодорхойлох боломжийг туршсан судалгааны дунг энэ ажлаар узүүлэв.

ОРШИЛ

Тарваганы хүн махыг сүүлийн үед зарим нэгэн архаг хуучинд хэрэглэх болсон тухай мэдээлэл байдаг. Иймд түүний элементийн найрлагыг тодорхойлох тодорхойлоор электроны хурдасгуур ашиглан гамма идэвхжилийн аргаар судалсан шинжилгээний зарим үр дүнг илтгэж байна.

Зорилго. Сүүлийн жилүүдэд тарваганы хүн махыг элдэв евчин эмгэгийг элааршуулахад тухайлбал нойр булчирхайн өрөвсөлд хэрэглэх явдал өргөн болж байна. Энэ үүднээс түүний микро, макроэлементийн найрлагыг судлах асуудал судлаачдын сонирхолыг татаж байгаа юм.


Гамма идэвхжилийн шинжилгээний арга. Электроны шугаман болон цикл хурдасгуур ашиглан гамма идэвхжилийн шинжилгээг өргөн хийж байна [1-5]. Дээж шарсан байдал, цацрагийн бууралтыг тооцох аргыг өмнөх "Шүдний хатуу эдийн найрлагыг тодорхойлох цөмийн физикийн судалгаа" сэдэвт ажилд бичсэнийг үзнэ үү.

ТУРШИЛТ, ҮР ДҮН

Хүн махны борц болон түүний үнсжүүлсэн нунтаг дээжүүдээ микротрон МТ-22 хурдасгуурын гамма цацрагийн шааралтын сувагт (1-р зурагт үзүүлсэн байрлалаар) 2 цаг шарсны дараа 20 мин. байлгаад 10 мин.; 5 цаг хүлээж 20 мин. буюу 24 цагийн дараа 1 цагийн турш НР Ge детектортой, 1.8-2.2 кэВ энергийн ялгах чадвартай гамма спектрометрээр хэмжсэн.

Тарваганы хүн махны үнс, борцонд хийсэн шинжилгээний дун Хүснэгт 1.

№	Элементүүд	Хүн махны үнс, мг/кг	Хүн махны борц, мг/кг
1.	Na	600 ± 80	3,6±0,5
2.	Mg	7000 ± 100	445±13
3.	Ca	290 ± 5	-
4.	Fe	8000 ± 90	-
5.	Ni	1,04 ± 0,016	<0,5
6.	Co	0,099 ± 0,009	-
7.	I	0.050± 0.009	-
8.	As	< 0,004	-
9.	Sb	< 0,004	-
10.	U	<0,007	-
11.	Mo	< 0,002	-
12.	Cu	< 0,01	-
13.	Zn	< 0,01	-
14.	Mn	< 0,02	-
15.	Sc	< 0,02	-
16.	Tl	<0,04	-



Зураг 1. Микротрон МТ - 22 электроны хурдасгуурын гамма цацрагын шаралтын сувагт 2 цагийн турш шарсан 1,0914г. жинтэй хүн махны үнсний дээжийн 24 цагийн дараа 1 цаг хэмжсэн гамма спектр.

ДҮГНЭЛТ

Гамма идэвхжилийн шинжилгээний дүнд тарваганы хүн махны үнс, борцон доторхи эрдэс найрлагын тухай тодорхой мэдээлэл гаргах боломжтойг үзүүлэв.

Аннотация. Даны результаты исследования, проводимого в центре ядерных исследований НУМ, по определению некоторых макро и микроэлементов в существенной сальной железе тарбагана (тагмот) и ее золе с использованием гамма активационного анализа на циклическом электронном ускорителе (микротрон МТ-22).

АШИГЛАСАН НОМ, ЗОХИОЛ

5. Ш.Гэрбиш. Автореферат, 18-89-790, Дубна, 1989.
6. C.Segebade et.al. Photon Activation Analysis. WdeG, Berlin, New York. 1988.
7. Zdenek Randa & F. Kreissinger. Table I & II for GAA. Kutna Hora,
8. Ю.Н.Бурмистенко. Фотоядерный анализ сост. вещества. М. ЭАИзд.1986.
9. Ш.Гэрбиш и.др. Многоэлементный ГАА углей. 18-87-406, Дубна, 1987.